

2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/СТОУС-ын дагуу илэрхийлэгдсэн/

**“ИНВЕСКОР ББСБ” ХК
БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**



“ИНВЕСКОР ББСБ” ХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	“Инвескор ББСБ” Хувьцаат Компани (Цаашид “Компани” гэх) нь 2016 оны 04-р сарын 21-ний өдрийн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр анх үүсгэн байгуулагдаж 2019 оны 05-р сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржид хувьцааны 15%-ийг анхдагч зах зээл дээр нээлттэй арилжаалж хувьцаат компани болсон.		
Гэрчилгээ	2016 оны 03-р сарын 29-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6060854 тоот регистр бүхий 9015003118 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан. 2019 оны 06-р сарын 11-ний өдөр компанийн үйл ажиллагаанд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тусган 9010002004 тоот бүхий Улсын Бүртгэлийн Гэрчилгээг дахин шинээр авсан. 2020 оны 05-р сарын 28-ны өдөр тайлант хугацаанд шинээр нэмж үүсгэн байгуулсан салбаруудын мэдээллийг шинэчлэн бүртгүүлсэн.		
Тусгай зөвшөөрөл	Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05-р сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Банк Бүс Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/554 тоот гэрчилгээ авсан.		
Үндсэн үйл ажиллагаа	“Инвескор ББСБ” ХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, Төлбөрийн баталгаа гаргах зэрэг болно.		
Нэгтгэгдсэн охин компаниуд	“Инвескор Хэтэвч ББСБ” ХХК (Монгол улсын хуулийн этгээд)- 100%-ийг бүрэн эзэмшдэг “Золотой Стандарт ББСБ” ХХК (Киргиз улсын хуулийн этгээд)- 100%-ийг бүрэн эзэмшдэг “Покет КГ” ХХК (Киргиз улсын хуулийн этгээд)- 100%-ийг бүрэн эзэмшдэг “Инвескор Актив” ТЗК ХХК (Монгол улсын хуулийн этгээд)- 75%-ийг эзэмшдэг		
Хувьцаа эзэмшигчид		Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
	“Эс Ай Би Жэй Капитал” ХХК	60,968,730	85%
	Бусад	10,759,188	15%
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирал Дэд захирал Санхүү эрхэлсэн дэд захирал		Д.Баясгалан Х.Амгаланбаатар Р.Пүрэв
Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн нарийн бичиг		Б.Анхболд Д.Баясгалан Р.Мөнхтөр Г.Уянгахишиг Т.Тэлмэн Namiki Hirohito Ч.Хашчулуун Д.Энхбат Ч.Өнөржаргал А.Энэрэл
Байнгын хаяг	“Инвескор ББСБ” ХК Твин Тауэр-1 байр ,13 давхар Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс		
Аудитор	“БДО Аудит” ХХК Юнион Бюлдинг В блок, 15-р давхар, 1502 тоот, Юнескогийн гудамж, Нарны зам-62, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс		

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3-6 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Инвескор ББСБ” Хувьцаат Компани болон түүний охин компаниудын (Цаашид “Инвескор ББСБ” ХК-ийг “Компани”, “Инвескор Хэтэвч ББСБ” ХХК, “Золотой Стандарт” ХХК, “Покет КГ” ХХК, “Инвескор Актив” ХХК -иудтай хамтад нь “Групп” гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Группийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандарт (“СТОУС”) -ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Группийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.



Р. ПҮРЭВ
Санхүү хариуцсан дэд захирал

Огноо: 2021.03.17

Улаанбаатар хот, Монгол улс

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ИНВЕСКОР ББСБ” ХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Санал дүгнэлт

“Инвескор ББСБ” ХК болон түүний охин компаниудыг багтаасан групп (Цаашид “Инвескор ББСБ” ХК-ийг дангаар нь ‘Компани’, “Инвескор ББСБ” болон түүний охин компаниудыг хамтад нь ‘Групп’ гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2020 оны 12-р сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь группийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (‘НБЁЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу группээс хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Асуудлыг онцлох нь

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 45с, Тайлангийн өдрийн дараах үйл явдал-д анхаарлаа хандуулна уу. 2020 оны 01 сараас Дэлхий нийтээр тархсан COVID 19 цар тахлын тархалтын нөлөөллөөс хамааран группийн үйл ажиллагаа болон тайлангийн өдрийн дараах санхүүгийн үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлж болзошгүй үйл явдлуудын талаар тусгасан. Бид энэхүү асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудитын гол асуудал

Аудитын хариу

1

Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

Группийн нийт хөрөнгийн 70.91% (2019: 76.08%) - ийг харилцагчдад олгосон зээл эзэлж байна. Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлохдоо өнгөрсөн хугацаанд тохиолдсон алдагдлын түүхэн мэдээлэл дээр үндэслэн зээлийн бүтээгдэхүүн тус бүр дэх макро эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг авч үзэн магадлалаар таамагласан ирээдүйн мөнгөн урсгалын талаарх удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцоолдог. Тайлант жилийн эцэс дэх зээлийн үнэ цэнийн бууралтын гарзыг удирдлагаас тусгайлсан болон бүлгийн үнэлгээний загвар ашиглан тодорхойлсон. Ингэхдээ СТОУС 9 - ийн дагуу зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг 3 шатлалд хуваан авч үзэн хүлээгдэж буй алдагдлын загвараар үнэ цэнийн бууралтын тооцоолол хийсэн. Дэлхий нийтээр тархаад буй "COVID 19" цар тахалтай холбоотойгоор макро эдийн засгийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж зээлийн үнэ цэнийн бууралтын тооцооллыг хийсэн.

Ашигласан таамаглалууд зохисгүй байж болзошгүй учраас бид энэхүү удирдлагын тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан.

Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 21-аас үзнэ үү.

Зээлийн үнэ цэнийн тооцооллыг үнэлэхдээ бид дараах горимууд гүйцэтгэсэн:

- Группийн зээлийн үнэ цэнийн бууралт, хүлээн зөвшөөрөлт, хяналтуудыг бид үнэлсэн;
- Үнэ цэнийн бууралтын тооцоолол нь СТОУС 9-аар шаардсан арга, аргачлалын дагуу хийгдсэн эсэх нийцлийг шалгасан;
- Группийн зээлийн үнэ цэнийн бууралтын тооцоололд ашигласан зээлийн өгөгдлийн иж бүрэн байдал, ашигласан орц мэдээллийн найдвартай байдлыг шалгасан;
- Зээлийн ангилал үнэн зөв хийгдэж, насжилтыг зөв гаргасан эсэхийг шалгаж зохих журмын дагуу дахин ангилсан;
- Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлоход удирдлагын зүгээс ашигласан магадлалуудыг бид группийн зээлийн мэдээлэлтэй тулгасан;
- Хүлээгдэж буй зээлийн алдагдалтай холбоотой нэмэлт тодруулгууд нь хангалттай эсэхийг үнэлсэн;
- COVID 19 цар тахлын эдийн засагт үзүүлж буй нөлөөтэй холбоотойгоор Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлого, журмын компанид үзүүлэх нөлөөллийг авч үзсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа эсвэл заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх группийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС -ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ Нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас Нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Группийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Инвекор ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Л. БАЯРЦОГЗОЛ
“БДО Аудит” ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж, Нарны зам-62
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө



Огноо:

2021.03.17

“Инвескор ББСБ” ХК

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

	Тэм	2020 он мян.төг	2019 он мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6	29,147,505	19,362,985
Хүү болон түүнтэй адилтгах зардал	7	(6,755,193)	(4,072,393)
Зээлийн үнэ цэнийн бууралтын (зардал), буцаалт	21	(1,297,947)	(56,963)
Хүүгийн цэвэр орлого		21,094,365	15,233,629
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	8	450,277	666,504
Харилцагчтай байгуулсан гэрээний орлого		-	1,933,653
Ерөнхий ба удирдлагын зардал	10	(7,286,069)	(6,395,881)
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого/(зардал)	9	86,738	159,154
Үйл ажиллагааны ашиг		14,345,311	11,597,059
Үйл ажиллагааны бус бусад орлого/(зардал)	11	(197,738)	(109,753)
Бизнесийн нэгдлийн БҮЦ-ийн хэрэгжсэн тохируулга	12	205,010	-
Бусад олз,(гарз)	13	(634,311)	(279,702)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)		13,718,272	11,207,604
Орлогын албан татвар	14	(2,285,986)	(2,548,913)
Үргэлжилсэн үйл ажиллагааны ашиг		11,432,286	8,658,691
Зогсоосон үйл ажиллагааны алдагдал	15	27,888	-
Тайлант жилийн ашиг/(алдагдал)		11,460,174	8,658,691
Нэгж хувьцаанд ногдох ашиг	16	159.77	120.72
Тайлант жилийн ашгийн хуваарилалт			
Толгой компанийн эздэд хуваарилагдах		11,471,542	8,667,296
Хяналтын бус хувь оролцоонд хуваарилагдах		(11,368)	(8,605)
Бусад дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)			
Гадаад валют хөрвүүлэлтийн олз/(гарз)	17	(55,930)	16,463
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)		(55,930)	16,463
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)		11,404,244	8,675,154
Нийт дэлгэрэнгүй орлогын хуваарилалт			
Толгой компанийн эздэд хуваарилагдах		11,415,614	8,683,759
Хяналтын бус хувь оролцоонд хуваарилагдах		(11,368)	(8,605)

“Инвескор ББСБ” ХК

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Нэгтгэсэн Санхүүгийн байдлын тайлан**

	Тэм	2020 оны 12 сарын 31 мян.төг	2019 оны 12 сарын 31 мян.төг
Хөрөнгө			
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	18	17,585,673	5,146,144
Хугацаат хадгаламж	19	9,003,000	-
Хөрөнгө оруулалт	20	591,122	-
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	21	96,409,803	62,307,875
Бусад санхүүгийн хөрөнгө	22	1,534,116	3,599,750
Бусад санхүүгийн бус хөрөнгө	23	492,218	2,309,789
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	24	821,892	1,055,576
Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр	25	5,370,591	5,343,860
Хөрөнгө ашиглах эрх-цэвэр	26	1,149,538	1,494,136
Биет бус хөрөнгө-цэвэр	27	2,689,942	645,031
Гүүдвилл	28	292,627	-
Нийт хөрөнгө		135,940,522	81,902,161
Өр төлбөр ба өмч			
Өр төлбөр			
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	29	42,209,511	19,933,800
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	30	14,100,200	14,515,976
Бусад эх үүсвэр	31	14,689,798	-
ББСБ -аас гаргасан бонд	32	7,878,886	-
Бусад санхүүгийн өр төлбөр	33	1,629,551	3,719,957
Бусад санхүүгийн бус өр төлбөр	34	1,257,677	1,587,623
Болзошгүй өр төлбөр	35	774,303	774,303
Орлогын албан татварын өглөг	14	703,802	981,808
Нийт өр төлбөр		83,243,728	41,513,467
Өмч			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	36	16,282,237	16,282,237
Нэмж төлөгдсөн капитал	37	15,377,738	15,377,738
Хуримтлагдсан ашиг		21,088,492	8,715,614
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	17	(55,930)	16,463
Хяналтын бус оролцоо	38	4,257	(3,358)
Нийт өмч		52,696,794	40,388,694
Нийт өр төлбөр ба өмч		135,940,522	81,902,161

“Инвескор ББСБ” ХК

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан**

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Толгой компанийн эздэд хуваарилагдах	Хяналтын бус оролцоонд ногдох	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	16,282,237	15,377,738	16,463	8,715,614	(3,358)	40,388,694
Тайлант жилийн ашиг	-	-	-	11,471,543	(11,368)	11,460,175
ХБХО-ны хувь нийлүүлсэн хөрөнгө	-	-	-	-	15,625	15,625
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал)	-	-	(72,393)	-	-	(72,393)
Борлуулсан охин компанийн тохируулга	-	-	-	901,335	3,358	904,693
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг	-	-	(72,393)	12,372,878	7,615	12,308,100
Гаргасан хувьцаат капитал	-	-	-	-	-	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	16,282,237	15,377,738	(55,930)	21,088,492	4,257	52,696,794
2019 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	6,096,873	-	-	7,791,347	2,860	13,891,080
Тайлант жилийн ашиг	-	-	-	8,667,296	(8,605)	8,658,691
ХБХО-ны хувь нийлүүлсэн хөрөнгө	-	-	-	-	2,387	2,387
Гаргасан хувьцаат капитал	2,442,335	15,377,738	-	-	-	17,820,073
Нэрлэсэн үнийн өсөлт	7,743,029	-	-	(7,743,029)	-	-
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй ашиг	-	-	16,463	-	-	16,463
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)	10,185,364	15,377,738	16,463	924,267	(6,218)	26,497,614
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	16,282,237	15,377,738	16,463	8,715,614	(3,358)	40,388,694

13-90 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“Инвескор ББСБ” ХК

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан**

	Тэм	2020 он мян.төг	2019 он мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн татварын өмнөх ашиг		13,718,272	11,207,604
Тохируулга:			
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл	25	264,334	106,671
Хөрөнгө ашиглах эрхийн хорогдуулга	26	790,795	-
Биет бус хөрөнгийн хорогдуулга	27	176,089	24,977
Зогсоосон үйл ажиллагааны борлуулалтын өдрийг хүртэлх хуримтлагдсан ашиг дах нөлөө		886,777	-
Зогсоосон үйл ажиллагааг борлуулсны ашиг	15	(27,888)	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй (олз)	9	(102,874)	(201,736)
Охин компанийн хөрвүүлэлтийн ханшийн нөлөө	17	(72,391)	16,463
Зээлийн авлагын хүлээгдэж буй алдагдал	21	1,297,947	56,963
ӨБҮХХ-ийн үнэ цэнийн бүүралтын гарз	24	257,434	279,702
ӨБҮХХ-ийн борлуулалтаас үүссэн олз	13	(53,715)	-
Санхүүгийн хөрөнгө дах үнэ цэнийн бүүралт	22	334,494	-
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6	(29,207,308)	(19,362,985)
Санхүүгийн зардал	7	6,841,116	4,072,393
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	26	140,236	120,367
Хяналтын бус оролцоо		-	2,387
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг		(4,756,682)	(3,677,194)
Ажлын капиталын өөрчлөлт:			
Харилцагчдад олгосон зээлийн (өсөлт)/бүүралт		(29,920,000)	(27,591,562)
Бусад санхүүгийн хөрөнгийн (өсөлт)/бүүралт		(290,485)	(991,273)
Бусад санхүүгийн бус хөрөнгийн (өсөлт)/бүүралт		2,106,955	(2,177,613)
Бусад санхүүгийн өр төлбөрийн (өсөлт)/бүүралт		(2,110,544)	3,678,176
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн (өсөлт)/бүүралт		-	(580,288)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн урсгал		(34,970,756)	(31,339,754)
Төлсөн орлогын албан татвар		(2,563,992)	(1,874,209)
Хүлээн авсан хүү		25,209,479	13,276,306
Төлсөн хүү		(5,985,207)	(1,220,971)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(18,310,476)	(21,158,628)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	25	(972,822)	(1,430,895)
Борлуулсан өмч, барилга, тоног төхөөрөмж	25	681,757	668,729
Худалдан авсан биет бус хөрөнгө	27	(2,468,245)	(583,625)
Борлуулсан биет бус хөрөнгө	27	247,245	-
Түрээсээр олж эзэмшсэн ашиглах эрхтэй хөрөнгө	26	(1,045,709)	-
Тайлант жилд хасагдсан ашиглах эрхтэй хөрөнгө	26	459,275	-
Худалдан авсан хөрөнгө оруулалт		(3,424,218)	-
Худалдсан зогсоосон үйл ажиллагаа		1,676,444	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(4,846,273)	(1,345,791)

13-90 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“Инвескор ББСБ” ХК

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан(үргэлжлэл)**

	Тэм	2020 он мян.төг	2019 он мян.төг
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хувьцаа гаргалт		-	17,820,073
Гаргасан бонд	32	7,927,398	-
Бондын эргэн төлөлт	32	(319,000)	-
Авсан зээл болон өр төлбөр	30	10,561,631	2,641,586
Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт	30	(10,720,209)	(3,740,000)
Харилцагчаас татсан итгэлцэл	29	42,972,955	17,660,744
Харилцагчдад төлсөн итгэлцэл	29	(6,749,897)	(9,135,930)
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлбөрийн төлөлт	26	999,868	-
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		44,672,746	25,246,473
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт		21,515,997	2,742,054
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,19	5,146,144	2,320,122
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(73,468)	83,968
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,19	26,588,673	5,146,144